



**АЙТҮҮЛС ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2024 оны 4-р сарын 19-ны өдөр

Дугаар 24/001

Улаанбаатар хот

*Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх
ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах тухай*

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9, Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8-д заасныг тус тус удирдлага болгон Айтүүлс ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцсэний үндсэн дээр 2024 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын шийдвэр, Тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь:

1. Айтүүлс ХК-ийн 2023 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хавсралтаар баталсугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА



Г.ХАТАНБОЛД



**АЙТҮҮЛС ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2024 оны 4-р сарын 19-ны өдөр

Дугаар 24/002

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, 77 дугаар зүйлийн 77.1, 77.4, Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8-д заасныг тус тус удирдлага болгон Айтүүлс ХК-ийн 2024 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. Айтүүлс ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр сонгосугай. Үүнд:

Ердийн гишүүд:

1. А.Баттамир
2. Д.Бүнчинсүрэн
3. Г.Хатанболд
4. Л.Золбаяр
5. Ч.Мөнхжаргал
6. З.Төрболд

Хараат бус гишүүд:

1. Г.Гантуяа
2. Н.Жавхлан
3. З.Саранчимэг

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА



Г.ХАТАНБОЛД



АЙТҮҮЛС ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 4-р сарын 19-ны өдөр

Дугаар 24/003

Улаанбаатар хот

*Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны үйл ажиллагаа, гишүүдийн цалин,
урамшууллын төсвийг батлах тухай*

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13, Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8, Айтүүлс ХК-ийн 2024 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Айтүүлс ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны зардал болон гишүүдийн цалин урамшууллын төсвийг **48,254,240 /дөчин найман сая хоёр зуун тавин дөрвөн мянга хоёр зуун дөч/** төгрөгөөр баталсугай.
2. Төсвийн задаргааг Хавсралтаар баталсугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА



Г.ХАТАНБОЛД